



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2020 оны 3 дугаар сар


Улаанбаатар
2020



1 Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өсч 20.5 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 4.0 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 3.0 нэгж хувийг гадаад валютын харилцах, -0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -0.8 нэгж хувийг төгрөгийн харилцах, -2.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байна.


Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 3.8%-иар нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Монголбанк

Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 0.7 хувиар буурсан нь улс болон бусад санхүүгийн байгууллагын төгрөгийн хадгаламж буурсантай холбоотой байна. Харин улсын байгууллагын төгрөгийн болон гадаад валютын харилцах нэмэгдсэн байна.

Зураг 1-2: M2 мөнгө өмнөх сараас 0.7 хувиар буурав.




Эх сурвалж: Монголбанк

Нийт хадгаламжийн хэмжээ 14.4 их наяд төгрөг байгаагаас 87.0 хувь буюу 12.5 их наяд төгрөг нь иргэдийн, 13.0 хувь буюу 1.9 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна.

Нийт хадгаламжийн 25.6 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 24.9 хувийг, байгууллагын хадгаламжийн 30.3 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.


Зураг 1-3: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 2.6%-иар өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 17.8 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 2.6 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 8.2 нэгж хувийг ГЦА, -4.4 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна.

Зураг 1-4: M2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



Эх сурвалж: Монголбанк

ГЦА-ын өсөлтөд өмнөх саруудтай адил Төв банкны гадаад цэвэр актив нэмэгдсэн нь нөлөөлсөн бол ДЦА-ын бууралтад банкуудын зээл олголт буурсан болон “МИК ОССК”-д ипотекийн зээл шилжүүлсэнтэй холбоотой байна.

2 Банкуудын зээл

2.1 Зээлийн өсөлт

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар буурч 17.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс хувийн байгууллагын зээл 3.2 хувиар өсч 8.3 их наяд төгрөгт, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 6.5 хувиар буурч 8.5 их наяд төгрөгт хүрчээ. Тайлант сард банкууд 182.6 тэрбум төгрөгийн иргэдийн ипотекийн зээлийг “МИК ОССК”-ийн гаргасан ИЗББ-оор солив.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл 17.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар буурав.




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн 11.2 хувь буюу 1.9 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын зээл байна.

2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 42.9 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 809.4 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Зураг 2-2: Тайлант сард 1,300.1 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1,293.4 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдлөө.




Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон зээлийн 10.5 хувь буюу 136.2 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

2.3 Чанаргүй зээл

Чанаргүй зээлийн 78.9 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 80.8 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Зураг 2-3: Нийт зээлийн 10.8% нь чанаргүй зээл, 6.7% нь хугацаа хэтэрсэн зээл байна.




Тайлбар: * үйл ажиллагаа явуулж буй 13 банкаар
Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,826.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 9.1 тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээлийн 14.1 хувь нь гадаад валютын зээл байна.

Чанаргүй зээлийн 22.1 хувийг боловсруулах, 21.6 хувийг уул уурхай, 11.6 хувийг барилга, 9.1 хувийг үл хөдлөх, 7.6 хувийг худалдааны салбарын зээл эзэлж байна.

Зураг 2-4: Чанаргүй зээлийн 78.9% хувийн байгууллагын, 20.0% иргэдийн зээл байна.




Эх сурвалж: Монголбанк

2.4 Хувийн байгууллагын зээл

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл тайлант сард өмнөх сараас 54.1 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлэв.



Эх сурвалж: Монголбанк

Хувийн байгууллагын зээлийн сарын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал, барилгын салбарын зээл 51.4 тэрбум төгрөгөөр, боловсруулах салбарын зээл 11.5 тэрбум төгрөгөөр, уул уурхайн салбарын зээл 4.0 тэрбум төгрөгөөр тус тус буурч, худалдааны салбарын зээл 11.3 тэрбум төгрөгөөр өсчээ.

Тайлант сард хувийн байгууллагад 602.2 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 18.5 хувь буюу 111.3 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-6: Худалдаа, уул уурхай, барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.




*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.
Эх сурвалж: Монголбанк

2.5 Иргэдийн зээл

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 161.3 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 2-7: Иргэдийн зээлийн 40% (МИК-д ишлжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 27%-ийг цалин тэтгэврийн зээл бүрдүүлэв.



Эх сурвалж: Монголбанк

Иргэдийн зээлийг задалж авч үзвэл, ипотекийн зээлийн үлдэгдэл 159.6 тэрбум (МИК-д ишлжсэн багцыг хассанаар) төгрөгөөр, цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдэл 19.7 тэрбум төгрөгөөр, автомашины зээл 5.5 тэрбум төгрөгөөр тус тус буурч, хадгаламж барьцаалсан зээл 8.6 тэрбум төгрөгөөр, картын зээл 5.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант сард иргэдэд 631.9 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 3.9 хувь нь гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-8: Иргэдийн зээлийн ихэнх хувийг хадгаламж барьцаалсан, цалин тэтгэвэр, картын зээл эзэлж байна.




*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.
Эх сурвалж: Монголбанк

3 Ипотекийн зээл

2020 оны 3 дугаар сарын байдлаар 97,136 зээлдэгч нийт 4,640.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 72,209 зээлдэгч 3,426.3 тэрбум төгрөгийн зээл авчээ.

Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 5.1%-д хүрэв.




Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 73.8 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.3 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 4.8 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.

Нийт ипотекийн зээлийн 16.8 хувь буюу 779.2 тэрбум төгрөгийн зээл орон нутагт ногдож байна.

Зураг 3-2: Нийт зээлийн 16.8% буюу 779.2 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



Эх сурвалж: Монголбанк

Орон нутгийн ипотекийн зээлийн 77.2 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 19.8 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 2.9 хувь нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.8 хувь нь хэвийн, 2.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.0 хувь нь чанаргүй зээл байна.

Зураг 3-3: Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 57.5 тэрбум төгрөгөөр, чанаргүй зээл 3.4 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.



Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 58.9 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 39.1 хувийг хөтөлбөрийн зээл, 2.0 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна. Тайлант сард 613 зээлдэгчид 46.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосон бөгөөд үүний 42.7% хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

Зураг 3-4: Тайлант сард шинээр 613 зээлдэгчид ипотекийн зээл шинээр олгожээ.




Эх сурвалж: Монголбанк

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн

үеэс 1.5 нэгж хувиар буурч, өмнөх сараас 0.7 нэгж хувиар өсч 11.5 хувьд хүрсэн байна.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оноос 1.5 нэгж хувиар буурчээ.




Эх сурвалж: Монголбанк

4 ХҮҮ

4.1 Шинээр татсан хадгаламж


2020 оны 3 дугаар сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 11.1 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 5.4 хувьд хүрчээ. Төгрөгийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурав.

Зураг 4-1: Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх сараас 1.3 нэгж хувиар өсөв.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-2: Шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 11.6%, хугацаагүй хадгаламжийн хүү 6.2% байна




Эх сурвалж: Монголбанк

4.2 Шинээр олгосон зээл


Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.6¹ хувь, гадаад валютын ЖДХ 10.5 хувьд хүрч шинээр олгосон төгрөгийн зээл өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурав.

Зураг 4-3: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 16.6% байна.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-4: Шинээр олгосон нийт зээлийн хүү өмнөх оноос 0.5 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк


¹ Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

Иргэдэд 631.9 тэрбум төгрөгийн зээл олгосноос дийлэнх нь буюу 74.9 хувь нь 2 жил хүртэлх хугацаатай байна.

4.3 Үлдэгдлээр хадгаламж

Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ 11.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.7 хувьтай байна. Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 11.5 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 4.7 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 10.6 хувьтай байна.

Зураг 4-5: Үлдэгдлээр жигнэсэн төгрөгийн хадгаламжийн хүү 11.4% байна.




Эх сурвалж: Монголбанк

4.4 Хүүний зөрүү

Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээл болон тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүүний зөрүү 2020 оны 3 дугаар сарын байдлаар 5.4 нэгж хувьд хүрэв.

Зураг 4-6: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 1.0 нэгж хувиар буурчээ.




Эх сурвалж: Монголбанк

4.5 Зээлийн үлдэгдэл

Төгрөгийн зээлийн үлдэгдэлд ЖДХ 17.1 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.3 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 18.1² хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 11.5 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.7 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.3 хувьтай байна. Нийт валютын зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 4-7: Иргэдийн зээлийн үлдэгдлийн хүү өнгөрсөн сараас 0.1 нэгж хувиар өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийн дийлэнхийг 2-5 жилийн хооронд төлөгдөж дуусах зээлүүд эзэлж байна.

Зураг 4-8: Зээлийн үлдэгдэл, хугацаагаар



Эх сурвалж: Монголбанк


² Хөтөлбөрийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

5 Инфляци

5.1 Улсын инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны 3 дугаар сарын байдлаар жилийн 6.4 хувь, сарын инфляци 0.7 хувь байна. Хүнсний барааны үнийн өсөлт нь мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлтөөр тодорхойлогдож байгаа бол хүнснээс бусад барааны өсөлтөд хувцас, бөс барааны бүлгийн үнийн өсөлт нөлөөлсөн байна.

Зураг 5-1: Улсын жилийн инфляци 6.4 хувьтай байна.




Эх сурвалж: УСХ

5.2 Улаанбаатар хотын жилийн инфляци

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 3 дугаар сарын байдлаар 6.8 хувь байгаа ба 3.8 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 3.0 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.

Хүнсний барааны бүлгийн үнэд мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт, хүнснээс бусад барааны үнэд хувцас, бөс бараа гутал, орон сууц, ус цахилгаан түлшний бүлгийн үнийн өсөлт нөлөөлжээ.

Зураг 5-2: УБ хотын жилийн инфляци 6.8 хувь



Эх сурвалж: УСХ

5.3 Улаанбаатар хотын сарын инфляци

Өмнөх сартай харьцуулахад УБ хотын хэмжээнд инфляци 0.7 хувьтай байна. Үүний 0.4 нэгж хувийг хүнсний бараа, 0.3 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Хүнсний барааны үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үнийн өсөлт, хүнснээс бусад бараанийн хувьд тээврийн хэрэгслийн бүлгийн үнийн өсөлт нөлөөлжээ. Харин агаарын зорчигч тээврийн үйлчилгээний хөлс буурсан байна.

Зураг 5-3: УБ хотын сарын инфляци 0.7 хувь.



Эх сурвалж: УСХ

6 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

6.1 Ам.долларын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,777.7 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2,769.0 төгрөг байв.

Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт.



Эх сурвалж: Монголбанк

6.2 Хятадын юанийн ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 0.8 нэгж хувиар чангарч 391.6 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 389.7 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 398.8 төгрөг байлаа.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт.




Эх сурвалж: Монголбанк


ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /сектороор/




Зураг 2.3. Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа /зээлийн төрлөөр/



Зураг 2.4. Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлтийн задаргаа /салбараар/




Зураг 2.5. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл



Зураг 2.6. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.7. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. Чанаргүй зээлийн дүн



Зураг 2.9. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.10. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.11. Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц



Зураг 2.12. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.13. Орон нутгийн зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/




Зураг 2.14. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь



3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Тухайн сард олгосон ипотекийн зээл, санхүүжилтийн эх үүсвэрээр



Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар




Зураг 3.3. Тухайн сард нийслэл хотод олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар




Зураг 3.4. Тухайн сард орон нутагт олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар




Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он




Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.7. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт




Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл



4. ХҮҮ

Зураг 4.1. Хугацаагүй хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Зураг 4.2. Хугацаатай хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт

